



Омни Актив

“ОМНИ АКТИВ ТЗК” ХХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

С.Бямбасүрэн /"Омни Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	6

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Омни Актив ТЗК" ХХК нь 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Омни Капитал ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Омни Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар С.Бямбасүрэн, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр П.Сэлэнгэ, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Нина нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Омни Актив ТЗК" ХХК нь 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр 5.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Омни Актив ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011830497
Регистрийн дугаар	6742904
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/01/12
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	01
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	50,000
ХБҮЦ (ширхэг)	50,000
ХБҮЦ (сая төг.)	2,500
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	14.5%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	360 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2023 онд ХБҮЦ-ны үндсэн төлбөрт 2.50 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 453.13 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үндсэн төлбөрийн үлдэгдэл болон сүүлийн буюу 8 дахь удаагийн хүүгийн төлбөрийг Хүснэгт 2-т харуулсны дагуу 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдөр төлж, барагдуулна.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2024/03/04	2,500,000,000	90,625,000	-

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

2023 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 2022 оны эцсийн үлдэгдлээс 22.73 хувиар буурсан бөгөөд энэ нь ХБҮЦ-ны үндсэн төлбөрийн 50 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдөр төлсөнтэй холбоотой юм.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.12.31	2023.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	3,614,205,569.18	2,792,796,218.11	-22.73%
Зээлийн дундаж үлдэгдэл	12,816,331.81	14,776,699.57	15.30%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	5.83%	1.90%	-3.93%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	24.41%	14.28%	-10.13%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	35.79%	35.77%	-0.02%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	48.73%	53.63%	4.90%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	8.17	9.80	20.01%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	21.53	26.06	21.02%
Сарын дундаж төлбөрийн дүн	891,574.92	946,338.36	6.14%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	6,367,246.09	4,408,386.57	-30.76%
Зээлийн тоо /нийт/	282	189	-32.98%
<i>Иргэн</i>	277	189	-31.77%
<i>Хуулийн этгээд</i>	5	0	-100.00%
Барьцаа хөрөнгийн үнэлгээ /нийт/	10,556,590,036.39	6,401,994,077.09	-39.36%
<i>Үл хөдлөх</i>	4,410,000,000.00	529,000,000.00	-88.00%
<i>Автомашин</i>	4,833,458,736.39	5,522,994,077.09	14.27%
<i>Хөдлөх хөрөнгө</i>	1,313,131,300.00	350,000,000.00	-73.35%
Чанаргүй зээлийн хувь	0.0%	0.00%	0.00%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	4,598,905,889.41	8,914,572,167.54*	
<i>Зээлийн үндсэн төлбөр</i>	3,422,345,541.52	6,667,331,547.10	
<i>Хүүгийн төлбөр</i>	1,175,541,367.36	2,244,421,854.95	
<i>Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр</i>	1,018,980.53	2,818,765.49	

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2023 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 249.70 сая төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Омни Актив ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 314.34 сая төгрөг, хадгаламжийн хүү 10.5 хувь, харилцах дансны үлдэгдэл 10.59 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд "Юу Эй Эф Ассет" ХХК нь "Омни Актив ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	185	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	88	870,382,199.97
3	Багцад нэмж бүртгэсэн	180	3,526,334,657.04
	Нийт	453	4,396,716,857.01

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Омни Актив ТЗК” ХХК-ийг “Омни Капитал ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Омни Капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2021 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХ-21/02 тоот шийдвэрээр С.Бямбасүрэн, С.Нина, П.Сэлэнгэ нарын ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн С.Бямбасүрэнг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 8 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2023.01.10	Санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталгаажуулах тухай	2022 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж 2023 оны 01 дүгээр сарын 10-нд СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
2	2023.01.23	Зарим арга хэмжээ авах тухай	“Growth finance аудит” ХХК-тай байгуулсан гэрээг цуцлах талаарх мэдэгдлийг “Growth finance” аудитын ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны дотор албан бичгээр мэдэгдэж, “Юнистар аудит” ХХК-г аудитороор сонгов.
3	2023.02.15	Зарим арга хэмжээ авах тухай	2022 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлантай танилцаж, жилийн эцсийн тайланг батлав. 2023 оны төсвийг батлав. “Юнистар аудит” ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрөл олгов.
4	2023.04.05	Жилийн санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх тухай	Компанийн аудитын тайлангийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөв.
5	2023.07.20	ТЗК-ийн 2023 оны 2-р улирлын санхүүгийн тайланг батлах тухай	ТЗК-ийн 2023 оны 2-р улирлын санхүүгийн тайланг баталгаажуулж, СЗХ болон МХБ-д хүргүүлэв.
6	2023.08.03	Зарим арга хэмжээ авах тухай	ХБҮЦ-ны үлдэгдэл төлбөрийг хуримтлуулж эхлэв. СЗХ-ны шалгалтын бэлтгэл ажлыг хангав.
7	2023.10.10	ТЗК-ийн 2023 оны 3-р улирлын санхүүгийн тайланг батлах тухай	ТЗК-ийн 2023 оны 3-р улирлын санхүүгийн тайланг баталгаажуулж, СЗХ болон МХБ-д хүргүүлэв.
8	2023.12.12	Зарим арга хэмжээ авах тухай	СЗХ-ны газар дээрх хяналт шалгалтын бэлтгэл ажлыг хангав.